

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.3 Авлага.....	13
3.5.6 Бараа материал	13
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.8 Өр төлбөр.....	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.7 Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	16
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	17
4. Менежментийн захидал.....	17
3.2 Харьяа байгууллагуудтай холбоотой асуудал	17
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УЦУОШТ	Ус цаг, уур орчны шинжилгээний төв



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА С.ЭНХТҮВШИН
ТАНАА

2021.03.25 № 01/384
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 34 зорилтын хүрээнд 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	29,441,078.2	43,245,381.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,004,627.7	8,104,996.8
120	Нийтлэг татварын бус орлого	3,004,627.7	8,104,996.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,436,450.5	35,140,384.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29,185,496.9	35,840,003.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,185,496.9	35,840,003.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,793,669.2	32,952,885.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,618,197.8	23,135,366.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,298,849.9	3,036,828.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	778,876.8	880,484.9
2104	Хангамж, бараа материалын зардал	765,595.0	1,292,953.6
2105	Норматив зардал	23,491.8	48,866.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,807,554.0	454,922.7
2107	Томилолт, зочны зардал	230,870.8	179,488.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,314,473.7	1,166,758.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,955,759.4	2,757,215.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	391,827.8	2,887,117.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	255,581.3	7,405,378.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,849.3	14,488.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	154,732.0	7,390,890.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	26,572,507.0	35,368,489.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	92,025.6	105,749.1
120	Нийтлэг татварын бус орлого	92,025.6	105,749.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,480,481.4	35,262,740.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,308,067.0	35,112,797.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,308,067.0	35,112,797.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,813,045.6	32,124,161.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,555,970.6	23,125,359.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,320,833.8	3,045,412.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	773,914.8	883,346.2
2104	Хангамж, бараа материалын зардал	487,187.1	529,245.5
2105	Норматив зардал	40,280.2	68,919.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,083,294.4	3,067,214.3
2107	Томилолт, зочны зардал	233,671.4	179,502.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,104,934.3	1,097,351.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	212,959.0	127,810.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	495,021.4	2,988,635.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	264,439.9	255,692.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	257,815.0	260,201.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	257,815.0	260,201.6
2200	Дотоод эх үүсвэрээр	257,815.0	260,201.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(257,815.0)	(260,201.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,624.9	(4,509.1)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,961.5	15,586.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,586.4	11,077.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,480,443.4	-	26,480,443.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	34,468.0	-	34,468.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,514,911.5	-	26,514,911.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(24,468.0)	-	(24,468.0)
5	Тайлант үеийн үр дүн	154,732.0	-	154,732.0
6	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,645,175.4	-	26,645,175.4
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	188,332.7	-	188,332.7
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,833,508.1	-	26,833,508.1
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(94,988.8)	-	(94,988.8)
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	11,811.7	-	11,811.7
11	Тайлант үеийн үр дүн	7,390,890.4	-	7,390,890.4
12	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	34,141,221.4	-	34,141,221.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,355,461,700.00	33,154,432,907.06	201,028,792.94	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,355,461,700.00	33,154,432,907.06	201,028,792.94	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,776,212,900.00	30,586,664,426.70	189,548,473.30	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,594,183,700.00	22,508,219,874.27	85,963,825.73	99.6
210101	Үндсэн цалин	15,722,368,600.00	15,682,419,854.54	39,948,745.46	99.7
210102	Нэмэгдэл	5,996,741,100.00	5,959,914,575.88	36,826,524.12	99.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	875,074,000.00	865,885,443.85	9,188,556.15	98.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,043,205,200.00	2,968,451,423.82	74,753,776.18	97.5
210201	Тэтгэврийн даатгал	2,139,677,600.00	2,072,677,304.57	67,000,295.43	96.9
210202	Тэтгэмжийн даатгал	225,881,500.00	224,462,775.89	1,418,724.11	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	180,705,400.00	179,905,676.91	799,723.09	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	45,176,600.00	44,691,345.83	485,254.17	98.9
210205	Эрүүл мэндийн даатгал	451,764,100.00	446,714,320.62	5,049,779.38	98.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	884,700,400.00	875,720,710.14	8,979,689.86	99.0
210301	Гэрэл, цахилгаан	421,687,400.00	416,218,770.99	5,468,629.01	98.7
210302	Түлш, халаалт	423,325,000.00	423,004,035.13	320,964.87	99.9
210303	Цэвэр, бохир ус	36,017,600.00	32,827,504.02	3,190,095.98	91.1
210304	Байрны түрээс	3,670,400.00	3,670,400.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	313,520,900.00	311,702,658.11	1,818,241.89	99.4
210401	Бичиг хэрэг	42,240,800.00	42,037,757.00	203,043.00	99.5
210402	Тээвэр, шатахуун	146,333,800.00	145,659,888.50	673,911.50	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,431,600.00	67,139,417.61	292,182.39	99.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,097,000.00	2,871,100.00	225,900.00	92.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,417,700.00	53,994,495.00	423,205.00	99.2
2105	Норматив зардал	54,628,300.00	54,456,705.00	171,595.00	99.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,590,100.00	36,576,500.00	13,600.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,038,200.00	17,880,205.00	157,995.00	99.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,998,664,800.00	2,989,473,892.01	9,190,907.99	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,978,456,700.00	2,969,593,390.01	8,863,309.99	99.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,952,300.00	6,627,280.00	325,020.00	95.3
210604	Урсгал засвар	13,255,800.00	13,253,222.00	2,578.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	87,945,800.00	87,365,040.00	580,760.00	99.3
210702	Дотоод албан томилолт	87,945,800.00	87,365,040.00	580,760.00	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	744,589,500.00	738,592,717.35	5,996,782.65	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	523,522,000.00	518,844,566.25	4,677,433.75	99.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,707,200.00	11,197,380.00	509,820.00	95.6
210803	Даатгалын үйлчилгээ	19,135,700.00	18,939,479.00	196,221.00	99.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,449,700.00	4,285,765.00	163,935.00	96.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,523,200.00	1,446,300.00	76,900.00	95.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	117,828,500.00	117,800,514.00	27,986.00	100.0
210807	Газрын төлбөр	27,913,200.00	27,572,243.10	340,956.90	98.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,510,000.00	38,506,470.00	3,530.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,774,300.00	52,681,406.00	2,092,894.00	96.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,047,600.00	34,360,843.00	1,686,757.00	95.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,726,700.00	18,320,563.00	406,137.00	97.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,579,248,800.00	2,567,768,480.36	11,480,319.64	99.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,579,248,800.00	2,567,768,480.36	11,480,319.64	99.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,585,500.00	42,585,500.00	-	100.0

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,536,663,300.00	2,525,182,980.36	11,480,319.64	99.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,355,461,700.00	33,154,432,907.06	201,028,792.94	99.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,285,531,700.00	33,048,693,768.06	236,837,931.94	99.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	33,285,531,700.00	33,048,693,768.06	236,837,931.94	99.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,930,000.00	105,739,139.00	(35,809,139.00)	151.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,880,000.00	50,348,200.00	(9,468,200.00)	123.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,050,000.00	55,390,939.00	(26,340,939.00)	190.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00	(10,000.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,812	3,794	18	99.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	26	26	-	100.0
610001	Төсвийн байгууллага	26	26	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,893	1,884	9	99.5
620001	Удирдах ажилтан	63	60	3	95.2
620002	Гүйцэтгэх ажилтан	1,699	1,705	(6)	100.4
620003	Үйлчлэх ажилтан	131	119	12	90.8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,893	1,884	9	99.5
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	26	24	2	92.3
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	22	22	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,845	1,838	7	99.6

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,899,045,116.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,864,445,116.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,763,098,832.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	617,139,943.00
210101	Үндсэн цалин	607,777,149.00
210102	Нэмэгдэл	9,362,794.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,960,541.00
210201	Тэтгэврийн даатгал	76,960,541.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,625,479.00
210301	Гэрэл, цахилгаан	1,991,965.00
210302	Түлш, халаалт	5,633,514.00
2104	Хангамж, бараа материалын зардал	217,942,821.00
210401	Бичиг хэрэг	31,207,150.00
210402	Тээвэр, шатахуун	140,534,404.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,819,871.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	224,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,156,836.00
2105	Норматив зардал	14,462,791.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,474,300.00
210502	Хоол, хүнс	922,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,065,991.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	247,552,274.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	119,217,353.72
210602	Тавилга	12,374,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,468,900.00
210604	Урсгал засвар	109,491,720.28
2107	Томилолт, зочны зардал	92,137,120.00
210702	Дотоод албан томилолт	87,637,120.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,548,802.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	409,579,595.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	546,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	91,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	236,500.00
210807	Газрын төлбөр	2,031,307.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,729,061.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,089,061.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,640,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,346,284.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,677,573.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,177,573.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,668,711.18
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	44,668,711.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,600,000.00
223001	Бусад хөрөнгө	34,600,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,894,525,976.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,894,525,976.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	659,222,526.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,507,634.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	636,847,089.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	479,948,727.18
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(4,519,140.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,586,419.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,067,279.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Энхтүвшин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн холбогдох хууль журмыг мөрдөн ажиллах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-аас 2021 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Ц.Цэрэнхүү нар гүйцэтгэв.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цаг уур, орчны шинжилгээний газар эрхэм зорилгоо “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
- Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цаг уур, орчны шинжилгээний газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 35,840.0 сая төгрөгийн 2 хувь буюу 716.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 15.5 сая, эцсийн үлдэгдэл 11.1 сая төгрөг болж, 4.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	15.5	11.1	(4.4)
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
Дүн	15.5	11.1	(4.4)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11.1 сая төгрөг нь Дундговь аймгийн УЦУОШТ-ийн ахмадын сангийн арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна:

Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн ажилчдын цалингаас НДШ-ийг илүү, ХХОАТ-ын хөнгөлөлтийг буруу тооцоолсон, хавсран ажилласны нэмэгдэл авч буй ажилчдын ур чадварын нэмэгдлийг 0.9 сая төгрөгөөр илүү тооцож олгосон;

Баянхонгор аймгийн УЦУОШТ 5 ажилтнаас 1.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй;

Говь-Алтай аймгийн УЦУОШТ нэмэлт санхүүжилтийн дансанд орсон 6.8 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг зөвшөөрөлгүй зарцуулсан;

Дархан-Уул аймгийн УЦУОШТ тайлант онд гэрээгээр гүйцэтгэсэн шинжилгээний орлогыг тулган шалгахад гэрээнд заасан 15 байгууллагын 1.9 сая төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэрээг дүгнээгүй, анхан шатны баримтыг үдэж, архивын нэгж болгоогүй;

Завхан аймгийн УЦУОШТ орлого хүлээн зөвшөөрөх журам, шинжилгээний захиалгын хуудас хөтөлдөггүйгээс шинжилгээний ажилтан нэхэмжлэх бичиж, орлогыг мөнгөн сууриар бүртгэсэн;

Дархан аймгийн УЦУОШТ тайлант онд ажилтнуудын илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон, байгууллагын дотоод журамд илүү цагийн хөлсийг хэрхэн тооцож олгох талаар тодорхой тусгаагүй;

Сүхбаатар аймгийн УЦУОШТ төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1.7 сая төгрөгийг илүү бодож олгосон байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 65.8 сая, эцсийн үлдэгдэл 43.8 сая төгрөг болж, 22.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.9	1.2	0.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.2	-	(0.2)
Татаас, санхүүжилтийн авлага	59.4	39.2	(20.2)
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Бусад авлага	5.3	3.4	(1.9)
Зээлийн авлага	-	-	-
Дүн	65.8	43.8	(22.0)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар харьяа 6 байгууллагын 43.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Хэнтий аймгийн УЦУОШТ 0.2 сая төгрөг, Өмнөговь аймгийн УЦУОШТ 1.0 сая төгрөг, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 1.2 сая төгрөгийн ажиллагчидтай холбогдсон авлага;
- Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн гадаад төслийн төсвийн үлдэгдэл 38.6 сая төгрөг, Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори нэр данс зөрүүгийн авлага 0.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага;
- Сүхбаатар аймгийн УЦУОШТ 1.5 сая төгрөг, Хэнтий аймгийн УЦУОШТ 0.3 сая төгрөгийн байгууллагаас авах авлага;
- Дундговь аймгийн УЦУОШТ-ийн 2017 онд ажлаас халагдсаны тэтгэмжийг байгууллагаас 2018 онд өгснийг аудитын шалгалтаар буцааж төлүүлэхээр үүсгэсэн авлагууд байна.

Хэнтий аймгийн УЦУОШТ 1.7 сая төгрөг, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн 16,8 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн УЦУОШТ, Баянхонгор аймгийн УЦУОШТ 0.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн УЦУОШТ 0.1 сая төгрөг, Орхон аймгийн УЦУОШТ 0.2 сая төгрөг, Ховд аймгийн УЦУОШТ 0.7 сая төгрөг, Цаг уур, орчны шинжилгээний газар 3.2 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулж ажилласан.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 5,293.3 сая, эцсийн үлдэгдэл 8,475.9 сая төгрөг болж, өмнөх оныхоос 3,182.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	3,493.6	6,063.4	2,569.8
Эм боох	35.3	35.1	(0.2)
Дуусаагүй үйлдвэрлэл	21.2	21.2	-
Бэлэн бүтээгдэхүүн	2.5	3.5	1.0
Бичиг хэргийн материал	86.5	93.8	7.3
Аж ахуйн материал	513.8	518.5	4.7
Сэлбэг хэрэгсэл	578.4	1,059.1	480.7
Түлш шатах тослох материал	50.9	51.3	0.4
Барилгын засвар	17.9	22.2	4.3
Бусад хангамжийн материал	465.2	579.8	114.6
Мал, амьтад	28.0	28.0	-
Дүн	5,293.3	8,475.9	3,182.6

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах цаг уурын шинжилгээний багаж хэрэгсэл, лент маягт, судалгааны ажлын радиогийн

сэлбэг хэрэгсэл, цаг агаарт нөлөөлөх сум пуужин, аэрологийн радио зонд, лабораторийн химийн бодис, шинжилгээний сав гэх мэт 3,989.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч нөөцөлсөн байна.

Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй болсон 630.2 төгрөгийн бараа материалыг акталж, устгасан байна.

Аудитын илрүүлэлт: Хөвсгөл аймгийн УЦУОШТ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын зардлын гүйлгээг улирлын эцэст бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан зөрчил илэрсэн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 42,780.6 сая, эцсийн үлдэгдэл 25,617.9 сая төгрөг болж, 17,162.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	10,838.1	9,088.7	(1,749.4)
Тээврийн хэрэгсэл	4,234.6	1,377.4	(2,857.2)
Машин тоног төхөөрөмж	17,405.9	5,884.1	(11,521.8)
Тавилга эд хогшил	922.9	223.1	(699.8)
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	1.2	-	(1.2)
Номын фонд	3.2	3.2	-
Бусад үндсэн хөрөнгө	307.4	152.8	(154.6)
Программ хангамж	275.2	193.9	(81.3)
Бусад биет бус хөрөнгө	8,792.1	8,694.7	(97.4)
Дүн	42,780.6	25,617.9	(17,162.7)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө данс нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 260.2 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 2,742.9 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 85.4 сая, бусад байгууллага, эх үүсвэрээс 2,926.3 сая, 3 байгууллагын газрыг үнэлж дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэж тайлагнаснаас нэмэгдсэн байна.

Балансаас балансад шилжүүлсэн 20.2 сая, 2 байгууллага авто тээврийн хэрэгслийг 25.5 сая төгрөгөөр дуудлага худалдаагаар худалдсан, акталсан 2,068.8 сая төгрөг, бусад 2,173.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Булган аймгийн УЦУОШТ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн барилга, биет бус хөрөнгө, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил дансанд ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөөгүй 69 нэр төрлийн үндсэн хөрөнгө; Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг давтан тооцоолоход тайлант онд худалдан авсан, шилжин ирсэн хөрөнгүүдээс 26.6 сая төгрөгийн 9 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7.6 сая төгрөг болж, 4.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	3.3	7.6	4.3
Ажилчидтай холбогдсон өглөг	3.3	7.6	4.3
Нийт дүн	3.3	7.6	4.3

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хэнтий аймгийн УЦУОШТ 7.0 сая, Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори 0.6 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 26,645.2 сая төгрөгийн эцсийн үлдэгдэл 34,141.2 сая төгрөг болж, 7,496.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/-
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,671.0	25,682.8	11.8
Хуримтлагдсан үр дүн	(3,809.1)	3,770.1	(39.0)
Өмнөх үеийн үр дүн	(3,963.8)	(3,620.7)	343.1
Тайлант үеийн үр дүн	154.7	7,391.0	7,236.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,783.3	4,688.3	(95.0)
Дүн	26,645.2	34,141.2	7,496.0

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга данс 92.2 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгө акталсан, 1.4 сая төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулсан, мөн ЦУОШГ-ын газрын үнэлгээнд 94.7 сая төгрөгийн элэгдэл тооцож бүртгэлийн алдаа гарсныг залруулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 36,012.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,590.9 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардлыг бууруулж 33,355.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан нийт зардлын 33,285.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 69.9 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 33,048.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 105.7 сая төгрөг төвлөрүүлж, 35.8 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг Баянхонгор, Дархан, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Орхон, Цаг уур, орчны шинжилгээний мэдээний газар, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн шинжилгээний газар тус тус давуулан биелүүлсэн байна.

Тайлант оны төсвийн гүйцэтгэл 99.4 хувьтай байгаа нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор зарим зардлын төсвөөс 236.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Цаг уурын салбарын нэгтгэсэн тайлангаар урсгал зардлын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зэрэг зардлуудыг дутуу зарцуулсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 233.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 27,205.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2020 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдэд 1,635.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас

гүйцэтгэлээр 1,519.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 115.3 сая төгрөгийн барьцааг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламж, гадаад төсөл хөтөлбөрөөс 659.2 сая, Засгийн газрын нөөц сангаас 118.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 636.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 479.9 сая төгрөг, нийт 1,894.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 1,864.4 сая, хөрөнгийн зардалд 34.6 сая, нийт 1,899.1 сая төгрөгийг зарцуулснаас 44.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цаг уур, орчны шинжилгээний газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хөрөнгө зарцуулах тухай тушаал, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 164.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсний хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 26 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 23 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 22 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн тайланд “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,713.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,017.3 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 8.0 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 545.8 сая төгрөгийн 15 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 141.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 36 зөвлөмжийг хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод аймгийн Халх гол сумын цаг уурын шинжилгээний өртөөний барилга барих гүйцэтгэгчээр Гангануур өргөө ХХК шалгарч 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдөр барилгын ажлыг хүлээлгэн өгөхөөр 49.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй УТ-2012/30 дугаартай барилга угсралтын ажлын гэрээг 2012 оны 6 дугаар сарын 5-нд байгуулсан байна.

Гүйцэтгэгч компанид нийт 39.9 сая төгрөгийн санхүүжилт олгосноос захиалагч байгууллага болох Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд 21.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчил

Аудитаар нийт 1,669.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,017.3 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 8.0 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 524.6 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 119.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Аудитын түүвэрт хамруулсан Улаанбаатар хотын УЦУОШТ-ийн 2020 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 21.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1.4 сая төгрөгийн тавилга эд хогшлыг актлахаар тооллогын комисс шийдвэрлэсэн боловч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.

3.1.2 Эрсдэл: Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэл хангахгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль хэрэгжихгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг цаашид УСНББОУС-т заасны дагуу санхүүгийн жилийн эцэст хөрөнгийн үнэ цэнэ, эдийг засгийн үр өгөөж хүртэж буй эсэхийг үнэлэн, үнэлгээнд үндэслэн актлах хөрөнгө болон дахин үнэлүүлэх, үнэ тогтоох шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Харьяа байгууллагуудтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,669.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,017.3 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 8.0 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 524.6 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 119.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2.2 Эрсдэл: Шат, шатны удирдлагын дотоод хяналт хангалтгүй, алдаа, зөрчил буурахгүй, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр: 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код: САГ-2021/10/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цаг уур, орчны шинжилгээний газар	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Улаанбаатар хотын УЦУОШТ-ийн 2020 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 21.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1.4 сая төгрөгийн тавилга эд хогшлыг актлахаар тооллогын комисс шийдвэрлэсэн боловч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.	22.5	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Энхтүвшин, Д.Отгонбаяр
2	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,669.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,017.3 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 8.0 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 524.6 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 119.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмжийг хүргүүлсэн байна.	652.1	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Энхтүвшин, Д.Отгонбаяр
3	Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод аймгийн Халх гол сумын цаг уурын шинжилгээний өртөөний барилга барих Гүйцэтгэгч компанид нийт 39.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч захиалагч байгууллага болох Цаг уур, орчны шинжилгээний газар 21.1 сая төгрөгөөр бараа материалын дансанд бүртгэлтэй байна.	21.1	Албан шаардлага өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	С.Энхтүвшин, Д.Отгонбаяр
	Дүн	695.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 407/А 0160056
СГГ-2021/10/СГА-725

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод аймгийн Халх гол сумын цаг уурын шинжилгээний өртөөний барилга барих гүйцэтгэгчээр "Гангануур өргөө" ХХК шалгарч, 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдөр барилгын ажлыг хүлээлгэн өгөхөөр 49.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй УТ-2012/30 дугаартай барилга угсралтын ажлын гэрээг 2012 оны 6 дугаар сарын 5-нд байгуулсан байна.

Гүйцэтгэгч компанид нийт 39.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч захиалагч байгууллага болох Цаг уур, орчны шинжилгээний газрын бараа материалын дансанд 21.2 сая төгрөгөөр бүртгэлтэй байна. Жич: /уг барилгын зөвхөн газар шороо, суурийн ажил хийгдсэн байдалтай байна/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 5.2-т "Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллах, зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Hichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325auditin 2-R Gazar 1.Docx

01680562

This image shows a full page of a document template designed for handwriting practice or general note-taking. It consists of approximately 28 evenly spaced horizontal dotted lines across the entire width of the page. The background is plain white, and there are no margins, headers, footers, or other markings present.

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.